

НИЙГМИЙН ШИНЭЧЛЭЛ БА СОЦИОЛОГИЙН СУДАЛГАА

С.Фомбо

Философийн ухааны боитор (PhD)

Манай орон 70 жил хамгаас эрхэмлэн замнаж явсан хөгжлийн социалист чиг хандлагаасаа салж зах зээлийн эдийн засгийн харилцааг баримталсан улс болох өөрчлөлт шинэчлэлтийг эхэлснээс хойш 10 гаруй жил өнгөрч байна. Энэ хугацаанд манай орны улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн салбарт огцом өөрчлөлтүүд гарч тэдгээрт нийгмийн сэтгэл зүй дасан зохицож ядаж явна. Олон түмний нүдэн дээр ил, далд гарч байгаа эдгээр өөрчлөлт, тэдгээрийн маргаашийн үр дагаварт итгэх, үл итгэхийн завсарт тээнэлгэлзэлд орогсод ч цөөнгүй. Харьцангуй богино хугацаанд хийгдсэн улс төр, нийгэм, эдийн засгийн эдгээр шинэчлэлүүдийн зарим нь нийгмийн амьдралд тэр бүр эерэг үр дүн үзүүлсэнгүй. Ялангуяа нийгмийн салбарт хийгдсэн либерал өөрчлөлтүүд "бэлэнчлэх" сэтгэлгээнд илт дассан "р" олны хувьд тэдний сэтгэхүйд нийцсэнгүй. 1990-ээд оноос эхлэлтэй эдийн засаг, санхүүгийн хямрал шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэнд улмаар нийгмийн амьдралын бүх хүрээнд нөлөөлсөн.

Нийгмийн шинэчлэлтэй холбогдон гарч байгаа асуудлуудыг социологийн шинжлэх ухааны үүднээс нэгтгэн дүгнэх шаардлага нэн хурцаар тавигдаж байна. Энэ шаардлагыг ямар нэг хэмжээнд хангахад социологичдын мэдлэг, дадлага, туршлага хэр зэрэг хүрэлцээтэй байгаа эсэх тухай асуудал бол цэвэр социологийн боловсролын түвшинтэй холбогдох нь хэн бүхэнд ойлгомжтой юм.

Социологийн судалгааны сектор ШУА-д байгуулагдаад 30 дахь, социологийн мэргэжлийн үндэсний боловсон хүчин бэлтгэх бие даасан социологийн тэнхим МУИС-д байгуулагдаад 11 дэх жилтэйгээ золгож байна. Сүүлийн үед МУИС-иас гадна хэд хэдэн дээд сургуульд социологийн сургалт явуулах болсноор 1970-аад онд "партизан"-ы аргаар бэлтгэгдсэн гарын хуруугаар тоологдох хэдхэн социологичдын дараагийн Үеийг авч явах залуу халаа хангалттай бэлтгэгдсэн гэж Үзэж болно. зөвхөн МУИС-ийн социологийн ангийг жил бүр 20-25 оюутан социологийн бакалавраар төгсч, тэдний 20-иод хувь нь магистрын зэрэг хамгаалсан байна. Социологийн ухаанаар докторын (Ph.D) зэрэг хамгаалсан эрдэмтэд гэхэд л 15 жилийн өмнөхөөс даруй 4 дахин өсчээ.

Нийгэмд гарч байгаа өөрчлөлтүүд, тэдгээрийн эерэг, сөрөг үр дагаврыг нухацтай судлан шинжилж, шинэчлэлийг түргэсгэх оновчтой хувилбар загварыг боловсруулах нь социологичдын эрхэм үүрэг билээ. Одоогийн хийгдэж байгаа ихэнх судалгаа олон нийтийн сэтгэл ханамжинд эерэг, сөрөг нөлөөлж буй хүчин зүйлийг тоочсон хувь, харьцаанаас хэтрэхгүй байна. Ийм учраас тоон шинжилгээнээс чанарын шинжилгээнд шилжих, үзэгдэл үйл явцын хэтийн төлөв хандлагыг тодорхойлоход онцгой анхаарах хэрэгтэй юм.

Манай нийгмийн өөрчлөлт, шинэчлэлд нөлөөлж байгаа нийгмийн хүчин зүйлсийг нэгдүгээрт, бусад оронд явагдаж байгаа өөрчлөлтүүд болон дэлхий ертөнцийн даяаршлалтай холбогдох хүчин зүйлс; хоёрдугаарт, зөвхөн манай орны хувьд ардчилал, зах зээлийн системд шилжиж байгаатай холбогдсон бүлэг хүчин зүйлс; гуравдугаарт, өнөөгийн монголчууд бидний нийгэм-сэтгэл зүйтэй холботой хүчин зүйлс гэсэн гурван томоохон бүлэгт хамруулж судлах шаардлагатай байна.

Өнөөгийн нийгмийн зөрчил бэрхшээл ганцхан манай орон төдийгүй пост социализмын орнуудад нэгэн адил тохиолдож байгаа учир тэдний туршлага ч бидэнд сургамжтай. 2000 онд Санкт-Петербург хотноо "Социологи ба нийгэм" сэдвийн дор зохиогдсон Бүх Оросын Социологичдын анхдугаар конгресст оролцогсод орчин үеийн социологи үзэл, онолын зөрчилт байдалд тулгараад байгааг цохон тэмдэглэхийн зэрэгцээгээр түүнээс гарах арга замын талаар ялангуяа, социологийн нийгмийн үүрэг, нэр хүндийг дээшлүүлэхийн тулд эн тэргүүнд судлах шаардлагатай зангилаа асуудлуудад ихээхэн анхаарал тавьжээ.

Пост социализмын орнууд (ялангуяа ОХУ) нийгэм, улс төр, эдийн засаг, үзэл суртлыг хамарсан системийн зөрчилт байдалтай байна.

(ОХУ-д жил бүр болдог социологичдын унлага 2000 оны 2 сарын 1-5 нд "Нийгмийн бодлого ба социологи" сэдвээр Москвагийн ойролцоох Руза хотод зохиогдох үеэр Оросын тэргүүлэх социологичид, улс төрчид 50 шинжээчдээс шуурхай санал асуулга явуулахад орос орон нийгмийн хямралт, бүр аюул нөмөрсөн байдалд ороход дараах иалтгаанууд нөлөөлсөн гэж үзжээ. Үүнд: үндэстний эрх ашгийг хамгаалсан бодлого алдагдсан (47%), хун амын нийгмийн ач холбогдол бүхий сонирхлыг үл тоомсорлосон (47%), эдийн засгийн ухаалаг, оновчтой бодлого алдагдсан (32%), засаг төрийнхөн хээл хахуульд автагдсан (28%), үндсэн хууль боловсронгуй биш, хууль тогтоох бааз суурь зөрчилтэй (19%), янз бүрийн нам, хөдөлгөөнийхний нэр төр хөөсөн үзэл бодол удирдагчдын нэгдсэн бодлого төлөвшихөд сөрөг нөлөөлсөн, мөн нэр хүндтэй хошуучлагч байхгүй байгаа зэргийг дурьджээ.)

Хүн төрөлхтний түүхээс үзэхэд ийм байдал иргэдийн дунд гаж зан суртахуун газар авч нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн норм хэм хэмжээ алдагдан эмх замбараагүй байдал газар авахад хүргэдэг. Ийм учраас социум дахь хүний зан араншинг судлах, улмаар түүнийг прогнозчлох нь үнэхээр нарийн асуудал ч гэсэн орчин үеийн хүний мөс чанар, сэтгэл зүйд гарч байгаа буюу цаашид гарах өөрчлөлтийг судлах онол, арга зүй, аргачлал боловсруулахад анхаарах хэрэгтэй байна.

Аливаа шинжлэх ухаан тухайн нийгмийн хөгжилд хэр зэрэг нөлөөлөх нь тэр салбарын мэргэжилтнүүдийн онол методологийн мэдлэгийн цар хэмжээнээс л шалтгаалдаг гэж үздэг. Нийгэм судлаачдын сэтгэлгээ нийгэмд болж байгаа өөрчлөлтийн араас нь дагах биш түүнээс өмнө, түрүүлж байж чиг хандлагыг тодорхойлдог байх ёстой.

Нийгмийн хөгжлийн үзэл баримтлалын талаар зарим социологичд янз бүрийн ойлголттой байна. Тухайлбал, "Нийгмийн өөрчлөлтийн социологи" гэдэг номондоо П.Штомк, хэдэн арван жилийн турш нийгмийн хөгжлийн онолыг шүүмжилсээр байгаад эцэст бүрэн үгүйсгэхэд хүрсэн. Түүний оронд нийгмийн өөрчлөлтийн талаарх модернизацийн онол гарч байна гэж бичиж байхад НҮБ болон дэлхий нийтээр эл дүгнэлтийг эс зөвшөөрсөн хандлага нэлээд газар авах болжээ. Жишээлбэл, 1995 онд Копенгаген хотноо хуралдсан НҮБ-ын бага хурлаас "Бүх улс орон нийгмийн хөгжлийн эл үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй" гэж зарлажээ.

НҮБ-ын мэргэжилтнүүд хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг боловсруулж практикт нэвтрүүлэн жил бүр хүний хөгжлийн талаар тайлан материал гаргаж байна. Тэд нэг ч орон өөрсдийн цаашдын хөгжлийн бололцооноос татгалзах ёсгүй гэж үздэг. Нэлээд социологичид дээрх байр суурийг баримталж байна. Ийнхүү хөгжлийн онолын эерэг үзлийг баримтлах болсон нь дэлхий нийтийн хэтийн төлөвийн талаар хүмүүс итгэл алдаж байгаатай холбоотой бололтой. Эдүүтээ дэлхий дахинд баян, ядуугийн харьцаа 1:60, Орост 1:40 байгаа тохиолдолд хүн төрөлхтөний дэвшлийн тухай яаж ярьж болох вэ гэж зарим нь үзэж байна. Гэхдээ энэ бүхэн бол сэтгэлгээний "сульдаа" ядуурал уу, аль эсвэл ямар нэг бодлоготой явуулга уу гэдгийг салгаж зааглаж ойлгох ёстой. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөнд өөрөө өөрсдийн хөгжлөө саатуулах механизм хэрхэн яаж бүрэлдсэнд социологичид нийгэм судлаачид хариулт өгөх ёстой. Энэ бол шинжлэх ухааны бүх шинэ мэдлэгийг синтезчлэх, социологийн хүрээнд шинээр цогцолбор байдлаар хандах хандлага (парадигм)-ын эрэл хайгуул хийхэд хүргэж байна.

Шинэчлэлтэй холбогдох социологийн боловсрол мэдлэгийн өөр нэг чухал асуудал бол нийгмийн атрибут шинж болсон зохион байгуулалтат чанарын тухай ойлголт юм. Аливаа нийгмийн хөгжлийн түвшин тухайн нийгэм хамт олон хэр зэрэг зохион байгуулалтанд орсноос шууд шалтгаалдаг гэдгийг хэн бүхэн мэдэх боловч өнөөгийн нийгмийн туршлагаас харахад уг асуудлыг мөн л судлахгүй анхаарлын гадна орхисоор өнөөг хүрч байна. Яагаад зарим хүмүүс нэгэн зэрэг хэд хэдэн байгууллагатай холбогдох чадвартай байдаг вэ? Яагаад одоо болтол байгууллагын гадаад дотоод орчны асуудлыг өндөрт авч үзсээр ирэв? Яагаад алив нэг хамт олон зохион байгуулалтат чанараа бүрэн илэрхийлж чаддаггүй вэ? Яагаад байгууллага, хамт олны дотор хүмүүс жинхэнэ ба зохиомол дүрийг үүсгэдэг вэ гэх зэрэг асуудлууд бол нийгмийн шинэчлэлийг жинхэнэ утгаар нь төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Зохион байгуулалтат чанар бол аливаа хүчний ердийн механик нэгдэл биш хүн бүрийн ухамсраар шүүгдсэн өргөн олны органик эрч хүч байдаг.

"Организованность" бол нийгмийн оршин тогтнох, хувьсан өөрчлөгдөхийн атрибут шинж нь юм. Хүний нийгмийн түүхэнд зохион байгуулалтгүй нийгэм байгаагүй, байх ч үндэсгүй юм. Ийм ч учраас түүх бол хүмүүсийн зохион байгуулалттай хэлбэрүүд харилцан солигдож ирсний түүх байдаг. Аливаа нийгэм, байгууллага, хамт олны дунд зохион байгуулалтын дарангуйлсан захиргаадалтын хэлбэр ноёрхож байна уу, аль эсвэл харилцан эрх тэгш байх зарчимд тулгуурласан хэлбэр нь давамгайлж байна уу, зохион байгуулалтын ийм хэлбэрийг тогтоон барьж байхад анхаарах хүчин зүйлсүүд юу юу байхыг нягтлан судлах нь нийгэм хамт олны хөгжлийн загварыг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг.

Эцэст нь, боловсролын социологийн судалгаанд анхаарал татаж буй зарим асуудлыг авч үзье. Өнөө үед сурган хүмүүжүүлэх ухааны болон аль ч шатны сургуулиудын сургалтын үр өгөөж өндөр байна гэхэд санал нийлэх хүн ховор байх байх аа. Боловсролын үйл явц нь бие хүний зөвхөн хөгжил төдийгүй түүний нийгэмшилтийн үйл явц бүхэлдээ багтаж байдаг учраас боловсролын онолын агуулгыг социологийн үүднээс өнөөгийн нөхцөлд уялдуулан шинэлэг байдлаар авч үзэхийн тулд дараах чиглэлүүдээр судалгаа хийх шаардлагатай байна. Үүнд:

1. Нийгэм-түүхийн дүн шинжилгээ. Нийгмийн байгууллын ямар хэв шинжид боловсролын ямар агуулга тохирч байв. Нийгмийн өөрчлөлтөөс хамаарч боловсролын агуулгад ямар өөрчлөлт, хандлагууд гарч байв.
2. Хөдөлмөрийн зах зээл ба боловсролын агуулга. Хөдөлмөрийн зах зээлд амжилт олоход хүмүүст ямар ямар бодит мэдлэг, чадвар, дадал, туршлагыг эзэмших шаардлагатай вэ?
3. Сургуулиуд юунд, яаж сургах хэрэгтэй вэ гэдэг асуудлаар олон нийтийн дунд санал асуулгын судалгаа хийх. Амьдралд ямар мэдлэг, чадвар, дадлыг зайлшгүй өгөх шаардлагатай байгаа талаар хүн амын янз бррийн бүлгийнхний саналыг судлан боловсролын агуулгын сэтгэл ханамжийн байдалд дүн шинжилгээ гаргах,
4. Ямар ямар мэргэжилтэн бэлтгэх нийгмийн шаардлага, хэрэгцээнд үнэлэлт өгөх зэрэг чиглэлээр сурган хүмүүжүүлэгчид социологичидтой үр ашигтай хамтран ажиллаж чадвал өнөөгийн боловсролын салбарын арай илүү өндөр шатанд гаргаж болох үндэстэй юм.